



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг.

Утас/Факс: (976) 7032-3253.

E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2019.10.20 № 157

танийн —ны № —г

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас
Хууль сахиулах байгууллагуудын төгийн хөргөсүүдийн урьдчилан
сэргийлэх чиг үүргийн хоригийн төгийн хөргөсүүдийн дунд хийсэн
гүйцэтгэлийн тайлланы хургуулж бэлэн,

Хавсралт 14 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Л. Ламаачин Л. Ламаачин



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн**



**Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байна.**

2017 он

УАГ-14/2017/09-ГА

2017 оны 10 дугаар сар

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>ӨВӨРХАНГАЙ ДАХЬ ТӨРИЙН АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор (Л.Ламаачин)</p> <p>Аудитын менежер (Д.Гансүх)</p> <p>Ахлах аудитор (Б.Чимэдцэрэн)</p> <p>Аудитор (С.Шийлэгмаа)</p> <p>Аудитор (Ч.Гантулга)</p> <p>2017 оны 10 дугаар сар</p> <p>Үг тайланг АГ-ын https://www.facebook.com/uuvurkhangai.audit facebook хаягаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70323833 дугаарын утас, 70323253</p>	<p>Товчилсон үгийн тайлбар 4</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5</p> <p>Бүлэг 1.1</p> <p>Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна.</p> <ul style="list-style-type: none">✚ Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиг үүрэг журмын дагуу хэрэгжиж байна.✚ Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөөвлөн хэрэгжүүлж байна.✚ Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоож байна.✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг оролцуулж байна.✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдээд мэдээлэх, сурталчлах сургалтуудыг зохион байгуулж байна. <p>Бүлэг 1.2</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна.</p> <ul style="list-style-type: none">✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна.✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна.✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангалттай байна. <p>Бүлэг 1.3</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд зарцуулагдаж буй төсвийн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.</p> <ul style="list-style-type: none">✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд хуульд заасны дагуу төсвийн хөрөнгийг төлөөвлөсөн байна.✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөө, санхүүжилт хууль, журамтай нийцэж байна.
---	---

<p>дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: (Өвөрхангай аймаг Арвайхээр сум 5-р баг Нутгийн удирдлагын ордон 405 тоот)</p>	<ul style="list-style-type: none"> ✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан зарим хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. ✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байна. <p>Дүгнэлт</p> <p>Зөвлөмж</p> <p>Холбогдох байгууллагын санал</p> <p>Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал</p> <p>Саналд өгсөн тайлбар</p> <p>Хавсралтууд</p>
--	--

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ГХУСА33	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ҮЕП	Улсын өрөнхий прокурор
ЦЕГ	Цагдаагийн өрөнхий газар
ТББ	Төрийн бус байгууллага
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМГ	Эрүүл мэндийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЗЦТ	Замын цагдаагийн тасаг

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалтын бүрэн эрхийн хүрээнд, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаал, ҮАГ-ГАГ/2017/09-ГА төлөвлөгөөг үндэслэн “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

“Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-тэй эсэхийг шалгаж, дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах үндсэн асуудлаар аудитыг гүйцэтгэсэн болно.
Үүнд:

- Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх

Хамрах хүрээ:

Аймгийн ИТХ, ГХУСА33, Цагдаагийн газар, Прокурорын газар, бусад холбогдох төрийн байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2015-2016 он, 2017 оны эхний хагас жилийн үр дүнг ирүүлсэн ажлын тайлан, холбогдох бусад материалд тулгуурлан гүйцэтгэв.

Аудитын арга зүй:

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагaa болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд дурдсан аудитын арга зүйг мөрдөж аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлт ашигласан. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх журам;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр;
- Цагдаагийн албаны тухай хууль;
- Прокурорын тухай хууль;

- Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль,
- Захиргааны хариуцлагын тухай хууль,
- Захиргааны өрөнхий хууль,
- Замын хөдөлгөөний дүрэм
- Иргэний хууль,
- Эрүүгийн хууль,
- Прокурорын байгууллагын тухай хууль,
- Гэр бүлийн тухай хууль,
- Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль,
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр"-ийн төлөвлөгөө;

Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Энэхүү аудитыг гүйцэтгэхдээ: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан ҮАГ-ГАГ/2017/09-ГА аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав. Аудитыг ахлах аудитор Б.Чимэдцэрэн, аудитор С.Шийлэгмаа, Ч.Гантулга нар 2017 оны 9 дүгээр сарын 23-аас 10 дугаар сарын 17-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байна.

БҮЛЭГ-1.1

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

1.1.1 Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиг үүрэг журмын дагуу хэрэгжиж байна.

Төрийн үндсэн чиг үүргийн нэг нь иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж хамгаалах, хууль зөрчигчдөд хариуцлага тооцох, нийгэмд шударга ёс, дэг журмыг тогтооход байдаг.

Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга тэргүүлж, ГХУСАЗЗ нь харьяа нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвт төлөвлөж, санхүүжүүлж байна.

Аж ахуй нэгж байгууллагууд өөрийн үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ

авч, ажилтнууддаа үүргийнхээ дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах сургалт, сурталчилгаа зохион байгуулж байна.

Ард иргэдийг гэмт хэрэг болон нийгэмд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөл, хор холбогдлыг олон нийтэд таниулах, сэрэмжлүүлэх чиглэлээр хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр нийтлэл, нэвтрүүлэг, сурталчилгааг бэлтгэн хүргэж байна.

1.1.2 Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Холбогдох байгууллагуудаас аймгийн ГХУСАЗ3-ийн төлөвлөгөөнд тусгах ажлуудыг авч нэгтгэн жилийн төлөвлөгөөг боловсруулж иржээ.

2015 онд зохион байгуулалтын чиглэлээр 20, сургалт сурталчилгааны чиглэлээр 3, хяналт шалгалтын ажлын чиглэлээр 6 ажил төлөвлөжээ. 2015 оныг “Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийг бууруулах” жил болгон зарлаж, тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.

Хууль зүйн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 1/3 дугаар “Ажил эрчимжүүлж, сахилга хариуцлагыг сайжруулах тухай” албан даалгаврын хүрээнд аймгийн ГХУСАЗ3, ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэстэй хамтран орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хууль сахиулах болон төрийн байгууллагуудын дунд гэмт хэрэгтэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, цаашдын хамтын ажиллагааны талаар “Гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт илтгэл, хэлэлцүүлгийг хийсэн байна. Уг хэлэлцүүлэгт 8 байгууллагын 40 гаруй албан хаагчид оролцож, тэдний гаргасан саналын дагуу хэлэлцүүлгээс гарах шийдвэрийг хэрэгжилтийг хангах байгууллага нэгж бүрд хандаж, зөвлөмж хэлбэрээр гарган холбогдох газруудад хүргүүлжээ.

2016 онд зохион байгуулалтын чиглэлээр 27, сургалт сурталчилгааны чиглэлээр 3, хяналт шалгалтын ажлын чиглэлээр 5 ажил төлөвлөжээ. Аймгийн хэмжээнд эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээгээр 2015 онд нийт 542 гэмт хэрэг гарсан нь өмнөх онтой харьцуулахад 50 гэмт хэргээр буюу 10.2 хувиар өсжээ. Үүнээс бусдын өмч хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг өмнөх оноос 115 хэргээр буюу 83.3 хувиар өссөнд нэн анхаарах шаардлагатай гэж үзээд 2016 оныг “Хулгайн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах” жил болгон зарлаж, 3 бүлэгт 35 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.


2017 онд удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр 18, сургалт сурталчилгааны чиглэлээр 8, хяналт шалгалтын ажлын чиглэлээр 5 ажил төлөвлөжээ. Аймгийн хэмжээнд эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээгээр 2015 онд нийт 542 гэмт хэрэг гарсан нь өмнөх онтой харьцуулахад 50 гэмт хэргээр буюу 10.2 хувиар өсжээ. Үүнээс бусдын өмч хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг өмнөх оноос 115 хэргээр буюу 83.3 хувиар өссөнд нэн анхаарах шаардлагатай гэж үзээд 2017 оныг “Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх” жил болгон зарлаж, энэ хүрээнд хүүхэд оролцсон гэмт хэрэг зөрчлийг бууруулах олон


талт арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, эцэг, эх, багш, сургууль, хамт олныг хамруулан зохион байгуулахаар 21 арга хэмжээ бүхий тусгай төлөвлөгөө баталжээ.

Тус аймгийн болон сум дундын Прокурорын газраас УЕП-ын 2015 оны А/21 тоот тушаалааар батлагдсан “Прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох аргачилсан заавар”-т уялдуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017 онд 24 ажил хийхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 17 ажлыг төлөвлөгөөнд заасан хугацаанд хийж гүйцэтгэжээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 16 шалгалт хийж, эрүүгийн нөхцөл байдал, эрүүгийн хууль тогтоомжийн талаар болон тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг 9 удаа судалж, Прокурорын байгууллагын үйл ажиллагааг болон хууль тогтоомжийг таниулах чиглэлээр яриа таниулга, сургалтыг 32 удаа зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 16 удаа мэдээ, мэдээлэл бэлтгэн гаргаж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх ажил зохиолгохоор прокурорын мэдэгдэл 63-ыг бичиж байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнуудад хүргүүлж, биөлэлт, үр дүнг нь тооцэж ажилласан байна.

Аймгийн Цагдаагийн газраас оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд нийт гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 477 хүлээн авснаас 240 буюу 50.3 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн нь өмнөх оны мөн үötэй харьцуулахад гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 151-ээр буюу 24 хувиар, гарсан гэмт хэргийн тоо 62-оор буюу 20.5 хувиар тус, тус буурсан эөрөг үзүүлэлттэй байна. Үүний шалтгаан нөхцөлийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын чанар, үр нөлөөтэй холбоотой гэж үзэж байна.


Аймгийн Цагдаагийн газар 2017 оны эхний хагас жилд 1290 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас:





Хүлээн авсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар харуулбал:

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 46.3 хувийг 5 хоногт, 53.4 хувийг 6-19 хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 96.3 хувийг 14 хоногт, 3.6 хувийг 15-28 хоногт тус, тус шийдвэрлэсэн байна.



1.1.3 Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоож байна.

Цагдаагийн байгууллага Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Цагдаагийн өрөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх өрөнхий газрын даргын хамтарсан 2003 оны 285/A/127, 2006 оны А/81/214 дүгээр тушаал болон холбогдох бусад эрх зүйн актын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ болох хорих ангиас хугацааны өмнө болон хугацаа дуусаж суллагдсан, шүүхээс ял тэнсэгдсэн, ял хойшлогдсон, өвчний улмаас ялаас чөлөөлөгдсөн хүмүүст захиргааны хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Захиргааны хяналтад байгаа болон Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдаж хорих ангиас суллагдсан иргэдийн судалгааг сум, багийн харьяаллаар нь гаргаж,

шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.3-т “сум, дүүргийн Засаг дарга ялтанд боловсрол, мэргэжил эзэмшихэд нь зохих туслалцаа үзүүлж, ялтны сахилга, шүүхээс даалгасан үүргийн биөлэлт, засрал хүмүүжлийн байдлыг шалган танилцаж, шаардлагатай бол цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцно” гэснийг хэрэгжүүлж ажиллах талаар сумдын Засаг дарга нарт албан тоотоор хүргүүлсэн байна.

Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгаас захиргааны хяналтад тавих хяналтыг чангатгах чиглэлээр сумдын хэсгийн төлөөлөгчид болон хэсгийн байцаагч нарын хяналт тавих үйл ажиллагаа хууль тогтоомжид заасны дагуу явагдаж байгаа болон хяналтын хувийн хэргийн бурдлийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгч биөлэлтийг хангуулан ажилласан байна.

Аймгийн Прокурорын газраас УЕП, ЦЕГ-ын даргын 2016 оны А/05, А/09 дугаар тушаалаар батлагдсан “Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам”-ын дагуу захиргааны хяналтын хувийн хэрэгтэй танилцаж, хянаад үүрэг, чиглэл өгч ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу нэг бүрчилсэн арга хэмжээний хүрээнд захиргааны хяналтад байгаа этгээдүүдийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, эрх зүйн зөвлөгөө өгч байна. Захиргааны хяналтад байгаа этгээдийн батлан даагч нарт эрх үүргийг танилцуулан гарын үсгээр баталгаажуулан хувийн хэрэгт хавсаргаж, засрал хүмүүжлийн талаар тодруулж, тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

Захиргааны хяналтад байгаа этгээдүүдийн судалгааг аймгийн Цагдаагийн газраас сар бүр гаргаж, ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах газарт хүргүүлж байна.

Захиргааны хяналт тогтоон ажиллахад дараах хүндрэлтэй асуудал гардаг байна. Үүнд:

- Хоригоос хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хяналтын хувийн хэргийг нээн ажиллахад уг этгээд нь өөрийн биөэр ирэхгүй хугацаа алддаг
- Хяналтад байгаа хугацаандаа ирэхгүй, хаяг тогтоогдохгүй тохиолдолд эрэн сурвалжлахад шаардагдах зардал байдаггүй
- Зарим тохиолдолд захиргааны хяналт тогтоолгох этгээд нь ирчхээд байхад шүүгчийн захираамж ирэхгүй, захиргааны хяналтын хувийн хэргийг нээж ажиллахад хүндрэлтэй байдаг
- Хоригоос өмнө тэнсэн суллагдсан этгээдэд захиргааны хяналт тогтоолгохоор харьяалагдаж байгаа нутаг дэвсгэрт нь захираамжийг хүргүүлэхдээ тухайн этгээдийн оршин суух хаягийг сайтар нягтлаагүйн улмаас хаяг өөрчлөгдөх, тухайн хаяг дээр байхгүй байдгаас уг этгээдийг олж тогтооход хүндрэлтэй байдаг байна.

Хоригоос суллагдсан болон захиргааны хяналтад байгаа этгээдүүдийг нийгэмшүүлэх ажлын хүрээнд аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн халамж,

үйлчилгээний хэлтэс, Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв, сумдын Засаг дарга настай хамтран сургалт зохион байгуулж байна.

1.1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг оролцуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, олон нийтийн хүчинд түшиглэх, иргэд оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ талаар зохион байгуулж байгаа ажилд оролцөх, аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо болон үйл ажиллагааныхаа хүрээнд гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах зарчимд тулгуурладаг байна.

Арвайхээр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар тогтоолоор журам батлагдаж, Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж буй ЕБС-үүд, MCYT-д ЕБС, түүний орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөх, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажилд сурагчдын эцэг эхийг татан оролцуулах замаар “School police” эргүүл зохион байгуулж ажиллаж байна.

Арвайхээр сумын ИТХ-ын тогтоолоор “Хөршийн холбоо” байгуулах журмыг хэрэгжүүлж, энэ ажлын хүрээнд хөршийн холбооны гишүүдтэй уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, “Итгэлцлийн гэрээ” байгуулан хамтран ажилласнаар гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэргийн гаралт 2017 оны эхний хагас жилд 40.7 хувиар буурчээ.

Аймгийн ИТХ-аас архинд донтох өвчтэй иргэдтэй ажиллах үүрэг бүхий аддиктологийн баг, мэргэжлийн багийг байгуулан ажиллах журмыг баталсан бөгөөд 2017 оны 4 дүгээр сараас эдгээр багийн ажлыг эрчимжүүлэн мэргэжлийн баг, бодлого зохицуулалтын багаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллуулж, аддиктологийн багуудыг жигд идэвхтэй санаачилгатай ажиллуулах, ажлын үр дүнг үнэлж дүгнэх зорилгоор эдгээр багуудын ажил дүгнэх журмыг баталжээ.

Байгаль орчны гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг иргэдээс төлбөртэй авах ажлыг төр, захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж байна.

1.1.5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдээд мэдээлэх, сурталчлах сургалтуудыг зохион байгуулж байна.

Аймгийн ГХУСАЗ3-ийн даргын баталсан удирдамжийн дагуу прокурор, цагдаа, хууль, хяналт, төр захиргааны байгууллагын ажилтнууд оролцсон ажлын хэсэг жил бүр сумдын ГХУСАЗ3-ийн ажлыг шалган танилцаж, заавар зөвлөгөө өгч, иргэдэд аймаг, сумдын эрүүгийн хэргийн гаралт, түүний шалтгаан нөхцөл, гэмт хэргийг бууруулахад иргэдийн оролцөө, архидан согтуурахтай тэмцэх ажилд анхаарах асуудлуудаар мэдээлэл хийж, ярилцлага зохион байгуулж ирсэн байна.

Аймгийн хэмжээнд 2015 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 32 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 28 хувиар өссөн, захиргааны зөрчил 103 бүртгэгдсэн нь

өмнөх онтой харьцуулахад 66 хувиар өссөн үзүүлэлттэй байсанд дүгнэлт хийж, аймгийн Цагдаагийн газраас “Бидний амьдрах гэрэлт ирээдүй” 2 сарын аян зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ГХУСА33-өөс гаргажээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын үүргийг сануулж, харилцан хамтран ажиллах талаар зөвлөгөөн зохион байгуулжээ. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээллийн нэгдсэн бүртгэл хөтөлж, холбогдох алба хаагчдаар эрсдэлийн үнэлгээ хийлгэж, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн сэтгэл зүйчид мэдэгдэж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд хүүхдүүдтэй ажилладаг төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүүхэд багачуудыг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох зорилгоор өртөөчилсөн сургалтыг танхимын бус хэлбэрээр ЕБС-ийн сурагчдын дунд “Бидний аюулгүй орчин-сургууль” аяныг зохион байгуулж, хүүхдүүдийн сонирхсон асуултуудад хариулт өгч, танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулжээ.

Архидан согтуурахтай тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо” сэдэвт онол практикийн бага хурал 2015 онд зохион байгуулж, хурлаас Арвайхээр сум, Цагдаагийн газар, Прокурорын газар, Эрүүл мэндийн газар, Эрүүл омогшил ТББ, Мэргэжлийн хяналтын газарт санал, олон нийтэд хандаж Санамж бичиг гаргасан байна.

Аймгийн хэмжээнд Архидалтгүй-Өвөрхангай хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор Архигүй орчин-Гэрэлт ирээдүй 3 сарын аяныг 2016 оны 4 дүгээр сарын 01-ээс эхлэн зохион байгуулж, хөтөлбөрийг үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлсэн сум, байгууллагыг шалгаруулж, шагнаж урамшуулсан байна.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр Архидалтгүй-Өвөрхангай хөтөлбөрийг аймгийн хэмжээнд 2014-2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн баталж, нийт сум, байгууллагууд хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд баасан гараг бүрд архи, согтууруулах ундааг худалдаалахгүй, түүгээр үйлчилдэггүй болж хэвшсэн байна. Үүний үр дүнд 2017 оны эхний хагас жилийн байдлаар согтуугаар 40 гэмт хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 11 буюу 20.3 хувиар буурсан нь хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй байна.

Аймгийн хэмжээнд архидан согтуурснаас үүдэлтэй зөрчил гаргуулахгүй байхад анхаарч иргэд, байгууллагад мэдэгдэл өгч, сурталчилгааны материал, гарын авлага, сэрэмжлүүлэг тараасан байна. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжоор 129 сургалт, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж 4144 иргэнийг хамруулсан гэх мэдээлэл байна.

Аймгийн ГХУСА33-өөс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль болон хүний эрхийн тухай холбогдох хууль тогтоомжоор Хууль зүйн туслалцааны төв, Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь салбарын мэргэжилтэнтэй хамтран Арвайхээр сумын 4 багийн 60 гаруй иргэнд, БОЭТ-ийн хүсэлтийн дагуу нийт сувилагч, үйлчилгээний ажилтнуудад, ХХҮГ-ын хүсэлтийн дагуу халамжийн асаргаа шаардлагатай зорилтот бүлгийн иргэдэд шинэчилсэн найруулга, онцлох зохицуулалтын талаар сургалт мэдээлэл өгчээ.

БҮЛЭГ-1.2

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна.

1.2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна.

Аймгийн ГХУСА33 хэргийн гаралт өсөлтөөс хамааран 2015 оныг “Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлийг бууруулах жил”, 2016 оныг “Хулгайн гэмт хэрэг зөрчлийг бууруулах жил”, 2017 оныг “Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх жил” болгон зарлаж, зарлагдсан арга хэмжээгээр тухайн хэргийн гаралт буурсан үзүүлэлтэй байна.

1.2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна.

Арвайхээр сумын МСҮТ-ийн болон ЕБС-ийн сурагчдын дунд Архи согтууруулах ундаа хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, хор уршиг нь үе тэнгийнхэнд чинь хэрхэн нөлөөлж буй болон түүнээс татгалзахыг уриалах агуулгыг илэрхийлсэн чөлөөт сэдвээр Эссэ бичлэгийн уралдааныг аймгийн ИТХ-ын дарга, ГХУСА33-ийн даргын удирдамжийн дагуу зохион байгуулсан байна. Уралдаанд 10 гаруй эссе ирснийг удирдамжид заасны дагуу аймгийн ГХУСА33-ийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг уншиж танилцан, байр эзлүүлсэн байна. Мөн Өвөрхангайн өнгө” сэтгүүлийн Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр нийтлэл, мэдээлэл бэлтгэн нийтлүүлэхээр 2015 оны 4 дүгээр сараас гэрээ байгуулан ажилласан байна.

Арвайхээр сумын ГХУСА33-өөс “Хөршийн холбоо байгуулах, ажиллуулах, үр дүнг тооцох журам”-г батлан гаргаж тус үйл ажиллагаанд зохицуулах зөвлөлийн зүгээс дэмжлэг болгон нийт дээрх 400 ахлагчийн үнэмлэхийн зардлыг шийдвэрлэж өгсөн байна.

Аймгийн ГХУСА33, ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, аймгийн Прокурорын газар, ЭМГ, БОЭТ, Цагдаагийн газар, МХГ, Хүүхдийн хууль зүйн хороо, Хархорин, Бат-Өлзий, Уянга сумдын ГХУСА33, “АА” ТББ, “Эрүүл омогшил” ТББ, хэвлэл мэдээллийн байгууллагууд оролцоон “Архидан согтуурахтай тэмцөхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо” сэдэвт онол практикийн бага хурлыг зохион байгуулсан байна.

Аймгийн МСҮТ болон Арвайхээр сумын ЕБС-ийн 11-12 дугаар ангийн сурагчдын дунд “Архигүй орчин-бидний гэрэлт ирээдүй” сэдэвт ДЭВЖЭЭ, АХА тэмцээнийг зохион байгуулж, хорт зуршлын хор уршиг, түүнээс өөрийгөө хамгаалах болон найз, нөхдөө хамгаалах арга зам, урьдчилан сэргийлэх, амьдралын эрүүл, зөв дадал хэвшил, ёс суртахууны тухай “**Спиртийг биш, спортыг сонгоё**” сургалт сурталчилгааны аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажилласан байна.

“Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлийг бууруулах жил”-ийн хүрээнд төлөвлөсөн ажлууд бүрэн амжилттай хэрэгжиж. Хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа болон өөр өөрийн бүрэн эрхийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлуудын үр дүнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 13 хэргээр буюу 8.8 хувиар буурсан үзүүлэлт гарсан байна.

2016 онд Хулгайн гэмт хэрэг зөрчлийг бууруулах жилийн ажлын хүрээнд тусгай төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, явц үр дүнгээ ГХУСАЗ3-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн ажилласан байна.

Тус ажлын хүрээнд үр дүнг дээшлүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Саршинэ”, “Цохилт”, “Хичээлийн шинэ жил”, “Камөр-1,2”, “Илрүүлэлт оргодол-2016” зэрэг нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан ажилсан байна. Мөн 62 удаагийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан байна. Хулгайн гэмт хэрэг зөрчлийг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнд 2016 онд хулгайн гэмт хэрэг 204 гарч, өмнөх оноос 49 хэргээр буюу 19.3 хувиар буурсан үзүүлэлт гарчээ. Мөн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн хэмжээнд “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хүүхэд бүрийн оролцоо” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарлаж, 11 сургуулийн 489 эссэ ирүүлсний 11 эссэг шалгаруулж, шагналыг гардуулжээ.

Арвайхээр төлөвистэй хамтран “Мотоциклийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” нэвтрүүлгийг бэлтгэж, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх МР-3 шторкыг З төрлөөр хийж, иргэдэд Цагдаагийн газрын гэрээтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд давтамжтайгаар хүргэж ажилласан байна.

Хулгайн гэмт хэрэг зөрчлийг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнд 2016 онд хулгайн гэмт хэрэг 204 гарч, өмнөх оноос 49 хэргээр буюу 19.3 хувиар буурсан үзүүлэлт гарсан байна.

2017 онд Зөвлөлөөс санхүүжүүлэн аймгийн Цагдаагийн газартай хамтран Хархорин суманд “Малын хулгайн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд бүсийн аймгуудын хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөнийг 2-р сарын 17-ны өдөр зохион байгуулсан байна. Зөвлөгөөнд Хангайн бүсийн Архангай, Баянхонгор, Булган, Хөвсгөл аймгуудын ГХУСАЗ3-ийн дарга нар болон Цагдаагийн газрын дарга, ЗЦТ-ийн дарга нар оролцжээ.

Тус зөвлөлөөс сумдын салбар зөвлөлийн дарга, ГХУСА хариуцсан түшмэл, олон нийтийн цагдаа нарын нэгдсэн сургалтыг 2017 оны 03 сарын 15-ны өдөр зохион байгуулсан байна. Сургалтаар:

- “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэл, анхаарах асуудал”,
- “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд оролцсон гэмт хэргийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал”,
- “Хулгайн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал”,
- “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх арга зүй”,

- “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”,
- “Гэр бүгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагаа”,
- “Малын хулгайн гэмт хэргийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвээр тус тус мэдээлэл хийсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр нь сургуулийн сурагчдын дунд Дэвжээ, АХА, сургалт сурталчилгаа, Эссэ бичлэгийн уралдаан, мөн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, бүсийн сургалт, нэгдсэн сургалт, онол практикийн бага хурал зэрэг арга хэмжээг амжилттай зохион байгуулсан байна.

1.2.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангалттай байна.

Аймгийн ГХУСА33 2015 онд 3 удаа хуралдаж, 6 тогтоол, 2016 онд 3 удаа хуралдаж, 3 тогтоол, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 2 удаа хуралдаж 2 тогтоол гаргаж ажилласан байна. Ирсэн бичиг 138 бүртгэгдэж, 103 албан бичиг холбогдох байгууллагуудад хүргэгдсэн байна.

Аймгийн ГХУСА33-өөс аймгийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн тодруулахаар Аймгийн Прокурорын газраар 2013, 2014 оны нийт гэмт хэрэгт судалгаа хийлгүүлсэн байна. Зохицуулах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж уг судалгааны дүнгээр 2015 онд аймгийн хэмжээнд Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргүүдэд анхаарч ажиллах шаардлагатай гэж дүгнэсний үндсэн дээр 2015 онд уг гэмт хэргүүдийг бууруулах чиглэлээр анхаарч ажилласан байна. Үүний дунд 2015 онд:

- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 23 хэргээр буюу 74.1 хувиар
- Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5 хэргээр буюу 8.0 хувиар
- Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 13 хэргээр буюу 8.2 хувиар тус тус буурсан үзүүлэлтэй гарч дэвшүүлсэн зорилтдоо хүрч ажиллажээ.

Тус зөвлөл нь жил бүр аймгийн Зохицуулах зөвлөлөөс сумдын салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаатай танилцаж, заавар зөвлөгөө өгдөг бөгөөд энэ жил Баян-Өндөр, Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Уянга сумдын Зохицуулах зөвлөлийн ажлыг шалган танилцаж заавар зөвлөмж өгсөн байна.

Ажлын хэсгээс дээрх сумдын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарт урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, тоон судалгаанд тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохиох, байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдийг энэ ажилд хэрхэн татан оролцуулах талаар зөвлөгөө өгч ажилласан байна.

Тус зөвлөлийн нарийн бичгийн дарга нь орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан байна.

- Өвөрхангай өнгө сэтгүүл
- Ноён-Уул FM 102.6

- Хас төлөвиз
- Таны элч сонин эдгээр байгууллагатай гэрээ байгуулан ажилсан байна.

Зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу 2017 онд сумдын салбар зөвлөлөөс 2017 онд зохион байгуулсан ажлыг дүгнэх, тэдгээрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор болзолт уралдаан зарлаж, шалгаруулалтыг нь оны эцэст дүгнэх юм байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангалттай ажиллаж байна.

БҮЛЭГ-1.3

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд зарцуулагдаж буй төсвийн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

1.3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд хуульд заасны дагуу төсвийн хөрөнгийг төлөвлөсөн байна.


Өвөрхангай аймгийн ГХУСА33-ийн үйл ажиллагааны зардалд 2015, 2016, 2017 онуудад дараах байдлаар төсөв хуваарилсан байна. Үүнд:

	2015 он	2016 он	2017 он
Төлөвлөсөн төсөв	75.3	81.0	89.9
ИТХ-аас баталсан төсөв	83.9	78.5	89.9
Төсвийн гүйцэтгэл	83.5	77.7	41.0

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагааны зардалд 2015 онд анх 75.3 сая төгрөг төлөвлөснийг баталж, 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын тогтоолоор 16.8 сая төгрөгөөр төсвийг нэмж тодотгож нийт 83.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 83.5 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна. 2016 онд үйл ажиллагааны зардалд 81.0 сая төгрөг төлөвлөсөн аймгийн ИТХ-аас 78.5 сая төгрөг баталж 77.7 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна. 2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагааны зардалд 89.9 сая төгрөг төсөвлөж, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 41.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр эүйлд заасны дагуу аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд сүүлийн гурван онд нийт 222.2 сая төгрөгийн төсөв хуваарилсан байна. Үүнийг графикаар

харуулбал:



1.3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв, санхүүжилт хууль, журамтай нийцэж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.2, 19.3.3, 19.3.4, 19.3.5 дэх заалтуудын дагуу хуваарилсан зардлыг зарцуулж байна. Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу олон нийтийн цагдаагийн ажилтныг сумдын Засаг даргын саналыг үндэслэн Цагдаагийн газрын даргын тушаалаар томилон, аймгийн ИТХ-ын дарга, Цагдаагийн газрын дарга олон нийтийн цагдаа нарын хооронд гурвалсан хөдөлмөрийн гэрээг байгуулан ажиллуулж, урамшууллыг олгож байна.


1.3.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан зарим хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан ихэнх төсвийн хөрөнгө үр дүнтэй зарцуулагдаж байгаа боловч зарим хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан тохиолдол байна. Үүнд:

- Аймгийн прокурорын газарт 2015 онд 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан олгосныг байгууллагын 85 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан
- Прокурорын байгууллагын ажилтан шүүх шинжилгээний явц дахь задлан шинжилгээний ажилд оролцсон тухай бүрд томилолтын зардал болон задлан шинжилгээнд оролцсоны нэмэгдэл нөхөн олговор 2.2 сая төгрөгийг 2015-2017 онуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлаас гаргасан

- Аймгийн ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлаас 2015, 2016 онуудад зочин төлөөлөгчийн буудлын зардалд 0.4 сая төгрөг, бэлэг дурсгалд 0.4 сая төгрөг зарцуулсан,
- Аймгийн Цагдаагийн газарт 2017 онд олгосон 3.0 сая төгрөгийг цагдаагийн байгууллагын бүсийн сургалт, спортын өдөрлөгт зориулсан зэрэг нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Нийт төсөв болон зориулалт бусаар зарцуулсан төсвийн харьцуулалт



Аймгийн ГХУСА33 болон Цагдаагийн газар, Прокурорын газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан санхүүжилтийг аудитад хамрагдсан гурван оноор хүснэгтээр харуулбал:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах төсөв /сая төгрөгөөр/

Зардлын төрөл	2015 он	2016 он	2017 он
Сумдад дэмжлэг үзүүлэх	5.9	7.8	11.8
Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийг бууруулах жилийн хүрээнд	4.0		
Хулгайн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах жил болгон зарлаж сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах		4.0	
Авлигын эсрэг гэмт зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа		1.0	1.0
Авлигатай тэмцэх олон нийтийн зөвлөлийн гишүүдийн урамшуулал			3.0
Зохицуулах зөвлөлийн гишүүд, прокурор сумдад заавар зөвлөгөө өгөх	0.6	0.3	
Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих иргэний зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох	10.0	7.8	5.6
Цагдаагийн байгууллагын ажилтнуудыг ухаалаг төхөөрөмжөөр хангах			4.0
Мэргэжлийн багаас зорилтод бүлэгт хийх сургалт			1.2
Хуулийн байгууллагуудын нэгдсэн аян			1.0
Сумдын ГХУСА33-ийн ажилтнуудын нэгдсэн сургалт			0.4
Хүүхэд гэмт хэргийн найз биш сургалт			1.0
Зам тээврийн осол гэмт хэргийг бууруулах зурагт самбар			0.3

Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн
хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн талаар гарын авлага тараах		0.5	
Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлэлцүүлэг		0.2	4.0
Олон нийтийн цагдаагийн урамшуулалт олгох	33.3	33.3	40.0
Олон нийтийн цагдаагийн хувцас хэрэгсэл		12.3	
Журмын хашааны сахиулын цалин		4.7	4.7
ОНЗ-ийн гишүүдтэй уулзалт хийх		0.1	
Архигүй орчин гэрэлт ирээдүй 3-н сарын аян		0.5	
Гэр бүлийн хүчирхийлэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох аян		0.4	
Зөвлөлийн ажилд зөвлөгөө өгөх		0.6	
Сумдын ГХУСАЗ3-ийн ажлыг сайжруулах болзолт уралдаан		1.4	1.4
ГХУС ажилд идэвхтэй оролцсон иргэдэд шагнал	0.6	0.8	0.5
Бидний сургууль-Аюулгүй орчин аян	0.8	0.8	
Нийслэлийн ГХУСАЗ3 ийн ажилтай танилцах туршлага солилцох		0.5	
Аймгийн ХХЗХ-ны ажиллах зардлыг шийдвэрлэх		1.0	
Үүрэн телефоны компаниудтай хамтран иргэдэд сээрэмжлүүлэг	0.7	0.7	1.4
Хяналт шалгалтын чиглэлээр	1.0	2.0	2.0
Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах	3.0	4.0	4.0
Зохиомжит нэвтрүүлэг бэлтгэн гаргах	2.0		
Бусад сургалт сурталчилгаа		10.0	2.5
НИЙТ ДҮН	75.2	81.0	89.9



1.3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, холбогдох байгууллагуудын санхүүгийн баримт болон цаасан тайланг хүлээн авснаар хяналтыг хязгаарлаж байна.

Аймгийн ГХУСАЗ3 болон Прокурорын газар, Цагдаагийн газраас гарсан зардал бүрийн бодит гүйцэтгэлд тавих шат дараалсан хяналт сул байгаагаас төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүсэж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цүглуулсан нотлох зүйлс, аудитын дунд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байна.

- + Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох чиг үүрэг журмын дагуу хэрэгжиж байна.
- + Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
- + Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоож байна.
- + Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, байгууллагыг татан оролцуулж байна.
- + Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдээд мэдээлэх, сурталчлах сургалтыг үр дүнтэй зохион байгуулж байна.
- + Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна.
- + Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаа хангалттай байна.
- + Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хуульд заасны дагуу төсвийн хөрөнгийг төлөвлөсөн байна.
- + Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөө, санхүүжилт хууль, журамтай нийцэж байна.
- + Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан зарим хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- + Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ГХУСА33-ийн дарга А.Ишдорж, нарийн бичгийн дарга А.Отгонцэцэг нарт:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төсөвлөсөн хөрөнгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд нийцүүлж, зориулалтын бусаар зарцуулахгүй байх

2017 оны 10 дугаар сарын 17

